

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (√) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд-сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хамтран баталсан.			√	
2.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуульд санал авахаар 2022 оны 12 дугаар сарын 20-ны 1/3296 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Монгол банкны ерөнхийлөгч, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагуудад хүргүүлэв.			√	
3.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/3421 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		√		
4.	Нийгмийн халамжийн тэтгэврийг 2023 онд нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох тооцоо, судалгааг батлагдсан төсөвт багтаан боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/3410 дугаар албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.		√		
5.	“Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам” болон “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын төслийг тус тус боловсруулан, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/3423 дугаар албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.		√		
6.	“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх шинжээчдийн ажлын хэсгийн 12 дахь хэлэлцээг 2022 оны 12 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд цахимаар зохион байгууллаа. Энэ удаа хэлэлцээрийн төслөөс гадна түүнийг хэрэгжүүлэх маягтын төслийг хэлэлцсэн. Дараагийн хэлэлцээг 2023 оны эхний улиралд хийхээр талууд тохиролцоонд хүрэв.			√	
7.	Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрээг бодлого, өгөгдлийн нэгтгэлийн хэрэгсэл болох EPIС (Every Policy is Connected) хэрэгслийг ашиглан боловсруулах сургалт, семинарыг Эдийн засаг, хөгжлийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисстой хамтран 12 сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Семинарын үр дүнд Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг Тогтвортой хөгжлийн зорилт, Инчеоны стратеги болон бусад олон улсын бичиг баримт, холбогдох салбарын статистик мэдээлэлтэй уялдуулан сайжруулсан.			√	
8.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулан Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/3248 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		√		

9.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-д “Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.” гэж заасны дагуу “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 12 дугаар 19-ний өдрийн 01/3295 тоот албан бичгээр яамдуудаас санал авахаар хүргүүлсэн.			√	
10.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар үзэл баримтлалын төслийг холбогдох тооцоо судалгаа, тооцооллын хамт боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлууллаа.			√	
11.	Барилга, хот байгуулалтын яамнаас үндэсний ажил мэргэжлийн ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ирүүлсэн 427 ажил, мэргэжлийн саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/119 дугаар тушаалаар баталсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлал”-ын дагуу санал нэг бүрээр судалж, европын ажил, мэргэжлийн ангиллыг жишээ болгон харьцуулан үзэж, холбогдох мэргэжлийн холбоодтой уулзалт, ярилцлага хийсэн. Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн саналаас 119 ажил мэргэжлийг дэмжиж, үүнээс 38 ажил мэргэжил шинээр нэмж, 64 ажил мэргэжлийн нэршилд өөрчлөлт оруулан 17 ажил мэргэжлийг хүчингүй болгож, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/210 тоот тушаалаар батлав.			√	
12.	Дараахь Засгийн газрын тогтоолуудыг батлууллаа. Үүнд: 1/ Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах 2/ “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах 3/“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоол 4/“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоол 5/ “Төрийн захиргааны албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам” Засгийн газрын тогтоол		√		
13.	Хөдөлмөрийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулав. Мөн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан, яамд, холбогдох газруудаас санал авч, Засгийн газраар батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.		√		
14.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч байна.			√	
15.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, хамтран батлахаар Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022.12.15-ны өдрийн 01/3256 тоот албан бичгээр хүргүүлэв.	√			
16.	Гэр бүлийн тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хүүхдийн тэтгэлгийн зохицуулалт, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажил үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээний хувилбар, мэргэжлийн удирдлагын зааврын төслийг төр, олон нийт, эрх ашиг нь хөндөгдөх хэсгийн төлөөллөөр хэлэлцүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан.			√	
17.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ, хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж, холбогдох стандарт болон эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахаар ажиллаж байна.	√			
18.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төр, төрийн бус байгууллагаас ирсэн саналыг тусган, үзэл баримтлалын төслийг шинэчлэн батлуулахаар			√	

	ажиллаж байна.				
19.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар холбогдох тооцоо, судалгааг хийж байна.			√	
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
20.	<p>“Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр”-ийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн хороодын ажилтнуудад зориулсан төгсөлтийн хөтөлбөрийн талаар нэгдсэн ойлголт өгөх зорилгоор өрх сонголтын процесс, өрхтэй хамтран ажиллах чиглэл болон хөтөлбөрт өрхийг хамруулах уулзалтад хэрхэн үүрэг хүлээж ажиллах талаар цахим уулзалтыг 12 дугаар сарын 16, 19 ний өдрүүдэд Улаан загалмай нийгэмлэг, “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн төслийн баг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон холбогдох ажлын хэсгийн гишүүд хамтран цахимаар хуралдаж цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож ажиллав. Туршилтын хөтөлбөрт хамрагдах өрхийг сонгох судалгааны ажлыг Нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, 39 хорооны 3147 өрхийг энэхүү судалгаанд хамруулав. Эдгээр өрхөөс “Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр”-т Чингэлтэй дүүрэг-257, Сонгинохайрхан дүүрэг-887, Баянзүрх дүүрэг-377 өрх буюу нийт 1520 өрхийг хамрагдахаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдлоо. Сонгогдсон өрхүүдэд хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх, уг хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг өрх бүрээр баталгаажуулах арга хэмжээг 2022 оны 12 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллав. Энэ арга хэмжээний талаар дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон 39 хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнуудад ХНХЯ, төслийн нэгж, зөвлөх багууд хамтран албан ёсоор цахим уулзалт зохион байгуулж урьдчилан зөвлөмж, чиглэл өгч ажиллав. <p>Уг хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн 39 хороонд зохион байгуулсан "Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр"-ийн талаар танилцуулсан видео нэвтрүүлгийг ТМ телевизтэй хамтран бэлтгэж, ХНХ-ын сайдын хэлэх үгийг бэлтгэлээ.</p>			√	
21.	ХНХЯ-ны зүгээс Дэлхийн банктai нийгмийн хамгааллын болон хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах талаар саналыг бэлтгэн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/3291 тоот албан бичгээр хүргүүлээ.			√	
22.	Дэлхийн Банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн “Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор SPSS, STATA программын эрчимжүүлсэн хөтөлбөрийн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтын байгууллага сургалтад хамрагдсан ажилтнуудын компьютер тус бүрт SPSS болон STATA программуудыг суулгаж, хөтөлбөрийн дагуу сургалтыг амжилттай зохион байгуулж оролцогчдод гэрчилгээ олголоо.			√	
23.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс санаачлан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хамтран "Монгол Улсын ядуурлыг бууруулах арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Цар тахлын дараах нийгмийн амьдралын хэв маягийн өөрчлөлт, технологийн эрин зуунд дасан зохицох, нийтийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх улмаар Монгол Улсын ядуурлыг бууруулахад судлаачдын оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагууд шинжлэх ухаанчаар бодлогын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, шинэ санааг нийтийн хүртээл болгоход энэхүү арга хэмжээ чиглэгдэж буй юм. Тус арга хэмжээнд ХНХ-ын Дэд сайд С.Зулпхар, ХНХСҮСИ-ийн захирал Б.Батцэцэг, ХНХЯ-ны сайдын зөвлөх, доктор П.Мөнхтуяа, ХНХЯ-ны Хүн ам, ядуурлыг бууруулах бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч С.Рэгзэн, ХХҮЕГ-ын Нийгмийн халамжийн бодлого хэрэгжилтийн газрын дарга Т.Бадрахбаяр, МУИС-ийн Бизнесийн сургуулийн доктор, профессор Н.Батнасан болон эрдэм шинжилгээний бага хурлын оролцогчид, холбогдох албан тушаалтнууд оролцлоо.			√	

24.	Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөлийг байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авахаар бэлтгэлээ. Тус зөвлөл нь Тогтвортой хөгжлийн зорилт-2030, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлого, олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд зөвлөмж, чиглэл өгөх, салбарын бодлого, төлөвлөлт, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөртэй уялдуулах, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, төсөв хөрөнгийн зарцуулалт, түүний үр нөлөөг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн үйл ажиллагааг явуулах юм.		√		
25.	Монгол Улсын хүн амын ядуурлын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсрууллаа. Энэ хүрээнд Ядуурлын дүр төрх-2020 судалгаа, Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд дүн шинжилгээ хийж, үндэсний болон салбарын бодлого, олон улсын төсөл хөтөлбөрийг уялдуулах замаар ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан.			√	
26.	Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын хоёр дахь удаагийн илтгэл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засаг хөгжлийн яам болон бусад холбогдох яамд, байгууллагуудыг оролцуулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэгт Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн ажиллаж байна. Үндэсний сайн дурын илтгэлийг 2023 оны 2 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын 2023 оны өндөр түвшний чуулга уулзалтад танилцуулагдах юм.			√	
27.	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д заасны дагуу ногдуулж буй ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2022 оны 02 дугаар сарын 16, 02 дугаар сарын 23-ны өдрүүдийн Засгийн газрын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэн, Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолоор батлууллаа. Журамд аж, ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөхөөр туссан. Тогтоолын хэрэгжилтийг ханган 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар "Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 13 удаагийн тушаалаар хүсэлт ирүүлсэн нийт 344 аж ахуйн нэгж, байгууллагын 4729 гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлсөн байна. Үүний дүнд 2022 оны 12 дугаар сард 177 аж ахуйн нэгжийн 3039 гадаад иргэнд нийт 3.748.598.000 төгрөгний ажлын байрны төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.			√	
28.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын "Цахим Монгол" зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем "Ejob" платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр албан ёсоор ашиглалтад орууллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/254 дүгээр тушаалаар байгуулсан "Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, мэдээллийн "Ejob" платформыг хүлээн авах комиссын гишүүд 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр цахимаар хуралдаж 13-19-ний өдрүүдэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тушаалын хавсралтын дагуу хүлээн авч санал хүсэлт, дүгнэлтээ гарган 20-ны өдрийн 14:00 цагт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хурлын танхимд хуралдан ажлын тайланг нэгтгэн, нэгдсэн дүгнэлт гаргаж Төрийн нарийн бичгийн даргад танилцуулав. Цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны А/204 дүгээр тушаалаар батлуулан ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно.			√	

	<p>“Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ. Уг систем нь “ХУР”, “ДАН” зэрэг төрийн бусад мэдээллийн системтэй холбогдож, хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохируулан хөгжүүлж, ажил хайх, ажил санал болгох үйл ажиллагааг уламжлалт арга барил буюу хувь хүний мэргэжил, боловсролд илүү тулгуурлан зуучилдаг байсан бол шинэ системд ажилд зуучлах алгоритм үүсгэж ажил хайгчдын ажлын туршлага, ур чадвар, чадамжийг харгалзан хүний оролцоогүйгээр системийн тусламжтайгаар ажилд зуучлах давуу талтай юм.</p> <p>Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.</p>				
29.	<p>“Жайка” олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2023-2027 онд хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай санамж бичгийг байгууллаа.</p>			√	
30.	<p>Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.</p> <p>Дээрх журмын 2.18-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан олгох банкийг сонгон шалгаруулах удирдамж”-ийг баталсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/177 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд олгох жижиг зээлийг 3 жилийн хугацаанд Улаанбаатар хотод болон аймгуудад дамжуулан зээлдүүлэх банкуудыг сонгон шалгарууллаа.</p> <p>Жижиг зээлийн эх үүсвэр 20.0 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд Улаанбаатар хотод 3 банкинд нийт 10.0 тэрбум төгрөг, аймагт 10.0 тэрбум төгрөгийг тус тус банкаар дамжуулан олгоно. Уг жижиг зээл нь дараах онцлогтой хэрэгжинэ. Үүнд:</p> <p>1. Жижиг зээлийн зориулалтаар Улаанбаатар хотод банкинд байршуулах зээлийн нийт эх үүсвэрт тооцох хүү 4.4 хувь, аймагт хуваарилсан эх үүсвэрийн үлдэгдэлд тооцох хүү 4.4 хувь тус тус байх бөгөөд банк нь хүүгийн төлбөрийг сар бүрээр тооцон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улирал бүр төлнө.</p> <p>2. Шалгаруулалтад оролцох банк нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд зээлдүүлэх жижиг зээлийн хүүгийн хувь хэмжээний талаар саналаа боловсруулан ирүүлнэ. Ийнхүү санал болгох хүүгийн хувь хэмжээ нь банк сонгон шалгаруулахад ашиглах үндсэн шалгуурын нэг болох бөгөөд Улаанбаатар хотод зээлийн нийт эх үүсвэрт ногдох 4.4 хувийн хүүг оруулаад жилийн 8.9 хувиас бага, аймагт зээлийн хүү 4.5 хувиас бага байна.</p>			√	
31.	<p>ОУХБ-тай хамтран ОУХБ-ын конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг дэмжих гурван талт дэд хорооны гишүүдэд зориулан “Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын конвенцын хэрэгжилтийн тайлан боловсруулахад анхаарах асуудал”, “Гурван талт зөвлөлдөөний талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ”, “Хөдөлмөрийн тухай 81, 129 дүгээр конвенцод нэгдэн ороход үндэсний хууль тогтоомжийн нийцлийн талаарх харьцуулсан судалгааны танилцуулга”, “Ажил хаях, ажлын байр түр хаахыг хориглох үед хүн амд үзүүлэх наад захын үйлчилгээний хэмжээ”, “Ажил хаях,</p>			√	

	ажлын байр түр хаахыг хориглоход нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт” зэрэг сургалт, хэлэлцүүлгийг ОУХБ-ын Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний асуудал хариуцсан мэргэжилтэн Алайн Пельсийг оролцуулан зохион байгууллаа.				
32.	ОУХБ-ын 138, 29, 105 дугаар конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулан Хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт салбар хороогоор хэлэлцүүлэн ОУХБ-д хүргүүлээ.			√	
33.	“Ажил хаях, ажлын байр түр хаахыг хориглох үед хүн амд үзүүлэх наад захын үйлчилгээний хэмжээ”, “Ажил хаях, ажлын байр түр хаахыг хориглоход нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ын төслийг боловсруулан ажлын хэсгээр хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудаас санал аван ЗГХЭГ-т хүргүүлээ.			√	
34.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Бодлогын шинжилгээ хийх тухай” А/234 дүгээр тушаал батлагдаж, Эрүүл мэндийн яам хамтран ажиллаж, хорт хавдартай хүүхдийн нийгмийн хамгааллын бодлого, эрх зүйн орчны судалгаа, хамгааллын зардлын тооцооллын дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах ажлыг эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд ЭМЯ болон ДЭМБ-аас хамтран зохион байгуулсан “Хавдаргүй үрс” зөвлөгөөнд “Хорт хавдартай хүүхдийн нийгмийн хамгаалал, эрх зүйн орчин” сэдвээр мэдээлэл хийж, санал солилцсон.	√			
35.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Хүүхдийн эрх, хамгааллын судалгааг зохион байгуулах тухай” А/245 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарсан уулзалт хийж, судалгааны ажлын зардлыг НҮБХС-аас дэмжихээр шийдвэрлэсэн. Судалгааны ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Боловсролын хүрээлэн, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран гүйцэтгэх бөгөөд 2022.12.12-ны өдөр ЭМЯ-ны Арга зүйн зөвлөлөөр судалгааны аргачлалаа хэлэлцүүлж, зөвшөөрөл авсан. Мөн 2022.12.16-17-ны өдрүүдэд ДЭМБ-ын төвийн болон бүсийн зөвлөхүүдээс судалгааны аргачлал боловсруулах, зохион байгуулахад анхаарах асуудлын талаарх арга зүйн сургалтыг авч, аргачлалаа сайжруулж байна.	√			
36.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Сургагч багш бэлтгэх тухай” А/240 дүгээр тушаалын хэрэгжилтийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын дэмжлэгтэйгээр “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд” хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх сургагч багшийн үндэсний сургалтыг 2022.12.12-15-ны өдрүүдэд анх удаагаа зохион байгуулсан. Уг сургалтад Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны аймаг, нийслэл, дүүргийн салбар хороодын 75 хүн, яам, агентлаг, төрийн бус байгууллагын төлөөлөл 50 орчим хүн хамрагдаж, сургагч багшаар бэлтгэн “Батламж” гардуулсан. ХНХЯ, МҮХАҮТ, МАОЭНХ, МҮЭХ-той хамтран 2023 онд байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд төлөвлөлттэй холбоотойгоор ХНХ-ын сайдын албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт сургагч багш нарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, судалгаа, төлөвлөлт гарган аймаг, орон нутагтаа төр, хувийн хэвшлийн байгууллагуудад хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг хүргүүлж байна.	√			
37.	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг хэлэлцүүлж, санал тусгах, хүүхдийн хөгжлийн үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, үйлчилгээний зураглалыг танилцуулах хэлэлцүүлгийг 2022.12.26-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтсийн болон хүүхдийн зуслан, ордон, төвийн мэргэжилтнүүд, судлаачдын төлөөлөл оролцож, стандартын төсөлд саналаа тусгаснаас гадна хөгжлийг дэмжих үйлчилгээний хүрээ, шаардагдах нөөцийг тодорхойлох, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг цогц байдлаар хөгжлийн онцлог, сонирхол, хэрэгцээнд тулгуурлан үзүүлэх асуудлыг хөндөж, санал солилцов.			√	
38.	“Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ын төслийг ТББ-аар хэлэлцүүлж, дахин ажлын байрны зураг авалт хийх шаардлагатай байгаа талаар нэгдсэн дүгнэлтэд хүрч, судалгааны ажлыг эхлүүлээ.			√	
39.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц”-ын хэрэгжилтийн талаарх 10 дугаар тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын			√	

	ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХНХ-ын сайдын 2022 оны А/211 дугаар тушаалаар батлуулж, Ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулсан.				
40.	Асрамж, халамжийн төвөөс насанд хүрч бие даан амьдрахаар гарч буй залуучуудыг дэмжих жишиг хөтөлбөрийг ХНХ-ын сайдын А/212 тоот тушаалаар батлуулав.			√	
41.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын гамшгийн үед авах арга хэмжээтэй холбоотой заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай саналыг ОБЕГ-т хүргүүллээ.			√	
42.	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон өрх, иргэний талаарх төрд байгаа мэдээлэлд тулгуурлан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам болон өрх, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Энэ хүрээнд ХНХ-ын сайдын 2022 оны А/189 дугаар тушаалаар төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх болон Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий 2 дэд ажлын хэсгийг байгуулж, ҮСХ, ХНХЯ, СЯ, ЦХХХЯ, Монгол банк зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна. Дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний статистикийн хороотой өдөр бүр үйл ажиллагааны явцын талаар мэдээлэл солилцож ажиллаж байна. • Аргачлалын загварын талаар гадаад зөвлөхтэй 3 удаа хуралдсан. Зарим үзүүлэлтийг хасаж тооцохоор болсоны дагуу дахин нэмэлтээр 7-8 загвар боловсруулсантай танилцсан. • Загварт ашиглагдах 12 байгууллагын 88 гаруй үзүүлэлтийн талбарыг боловсруулсан. Мөн нэмэлтээр дахин 7 байгууллагын 10 гаруй талбарыг шалгаж, ялган авсан. • Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох шинэчилсэн аргачлалыг урьдчилсан байдлаар боловсруулж, удирдлагуудад хянуулсан. • Мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх байгууллагуудын сервес хөгжүүлэх албан бичгийн төслийг бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлэв. • Мэдээлэл солилцох асуудлаар Татварын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтэстэй уулзалт зохион байгуулав. • Төрийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэн ажиллах тухай албан бичгийн төслийг бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлэв. • Мэдээлэл солилцох ажилтай холбоотойгоор мэдээлэл солилцох байгууллагуудын нэгдсэн уулзалтыг зохион байгуулав. <p>Өрхийн мэдээллийн санг бүрдүүлэх системийн процессын ерөнхий зураглалыг гаргаж ажлын хэсэгт танилцуулав.</p>			√	
43.	“Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөл болон төслийн танилцуулгыг бэлтгэн яамдаас санал авч Засгийн газрын хуралаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлэв.			√	
44.	Нийгмийн халамжийн захиргааны статистикийн тайлан 36 маягт, түүний нөхөх зааврыг эцэслэн боловсруулж, ХНХЯ-ны 2022 оны 12 дугаар сарын 15-ны 02/3261 дугаар бичгээр Үндэсний статистикийн хороогоор зөвшөөрүүлэхээр хүргүүлсэн.			√	
45.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн тайлангийн маягтын шинэчлэл хийж байна.			√	
46.	Эрүүл мэндийн яамны боловсруулсан “Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журам”-ын төсөлтэй танилцаж санал хүргүүлэв.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
47.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 55 дугаар тэмдэглэлд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан тэргүүтэй Монголын үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч С.Эрдэнэбат, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Д.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нарын төлөөлөгчид Бүгд Найрамдах Сингапур Улсад 2022 оны 12 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион			√	

	байгуулагдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн 17 дугаар ээлжит чуулганд оролцов.				
48.	Бүгд Найрамдах Сингапур Улсад 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын гүйцэтгэх захирал Конг Вай Ман болон ажлын албаны бусад хүмүүстэй мөн өдөр Орон сууцны хөгжлийн зөвлөлийн ахлах зөвлөх Фонг Чун Ватай нартай уулзалт хэлэлцүүлэг хийв.			√	
49.	Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан 2022 оны 12 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Сингапур Улсад зохион байгуулагдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн ээлжит 17 дугаар чуулганд оролцсон дүнгийн талаар хэлэлцүүлсэн. Тус хуралд Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал оролцов.			√	
50.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/248 дүгээр тушаалаар БНСУ-ын Сөүл хотын БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд зохион байгуулж 3 ажилтнаас шалгалт авсан.			√	
51.	БНСУ-ын Сөүл хотын шалгалтыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт болон хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, нийгмийн даатгалын цахим шилжилтийн талаар Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал төвийн албан хаагчдад мэдээлэл өгөв.			√	
52.	Монгол Улсын Засгийн газрын “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2012 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 153 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн в/ заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаар нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасантай холбогдуулан хариу тайлбарыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 03/423 дугаар албан тоотой хүргүүлэв.			√	
53.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний 4.25 дахь заалтыг хэрэгжүүлж Нийгмийн даатгалын сангаас олгох “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаатай холбоотой эмхэтгэл”, “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой тогтоол шийдвэрийн эмхэтгэл”, “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхэтгэл” гарын авлагын эхийг бэлтгэж, хэвлэлтэд өгөв.			√	
54.	Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журмыг шинэчлэн батлах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Бүх яамдаас санал авахаар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/3344 тоот албан бичгээр дахин хүргүүлэв.			√	
55.	Нийгмийн даатгалын 4 сангийн 2022 оны 11 дүгээр сарын мөнгөн урсгалын тайлан, танилцуулгыг хийж удирдлагуудад танилцуулав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж хэвийн олгогдож байна.			√	
56.	Үндэсний статистикийн хорооны “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тухайн оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл буюу “А” дансны лавлагаа, мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний статистикийн хороо,Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд албан тоот хүргүүлж санал авсан. Улмаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 03/3370 дугаар албан тоотой энэхүү ажлыг зохион байгуулах чиглэл өгсөн.			√	
57.	Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцох зөвлөмж батлах тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан Үндэсний статистикийн хороонд хүргүүлж 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/1036 дугаар албан бичгээр санал авсан.			√	

58.	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцох зөвлөмж батлах тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан Үндэсний статистикийн хороонд хүргүүлж 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/1045 дугаар албан бичгээр санал авсан.			√	
59.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам"-ын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багш нарыг бэлтгэх ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллага, их дээд сургуулийн багш, эрдэмтэдтэй хамтран 2022 онд нийт 118 сургагч багшийг бэлтгэсэн бөгөөд сургагч багш нарт гэрчилгээг гардуулах ажлыг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн н Үндэсний хорооны дарга С.Зулпхар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн н хөгжлийн хэлтсийн дарга З.Бауыржан нар оролцож сертификатыг гардуулав.			√	
60.	Эрүүл мэндийн салбарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд улсын үзлэгийг удирдамжийн дагуу 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулав. Дээрх ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны төлөөлөл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад улсын үзлэгийн үйл ажиллагааны явцтай танилцаж, хяналт тавин ажилласан. Улсын үзлэгт 21 аймаг, 9 дүүргийн 1056 эрүүл мэндийн салбарын байгууллага хамрагдлаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийн хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалт- 58,8%, Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал- 67,3%, Ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөл-64,7%-тай дүгнэгдэж улсын хэмжээнд 63,6% -ийн үзүүлэлттэй байна. Улсын үзлэгийн тайланд үндэслэн тухайн салбарт авч хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийн төслийг боловсруулав.			√	
61.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг нэгтгэж, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл болон ХАБЭА-н үндэсний хороонд танилцуулахаар бэлтгэв.			√	
62.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас олгох дэмжлэг, хөнгөлөлтийн хэрэгжилтийн явцад гарч байгаа зарим асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ e-halamj.mn халамжийн нэгдсэн системд шилжсэнтэй холбоотойгоор одоогийн процессыг өөрчлөх зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам", "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт тусламж үзүүлэх журам", "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам"-ыг тус тус шинэчлэн боловсруулж ХНХС-ын 2022 оны А/201 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлыг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж журмын төслийг боловсруулан холбогдох саналыг тусган ажиллаж байна.			√	
63.	Авлигатай тэмцэх газар, Хөдөлмөр нийгмийн яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас "Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа уялдаа, холбоо" сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ний өдөр хамтран зохион байгуулж, иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх шийдвэрийг гаргах явцад гарч буй хүндрэл бэрхшээл, уг үйл ажиллагаанд оролцогч төрийн анхан шатны нэгж болон Амьжиргаа дэмжих зөвлөлийн хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах асуудлаар хэлэлцэж зөвлөмж гарсан. Зөвлөмжийг 2022.12.05-ны өдөр Авлигатай тэмцэх газрын ахлах комиссар н.Ихмөрөн ХНХЯ-ны Дэд сайдад танилцуулж хүлээлгэн өгөх уулзалтыг зохион байгууллаа.			√	
64.	Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжилтын явц, үр дүн, тулгарч буй бэрхшээл, цаашид хэрхэн ажиллах талаар ХНХ-ын Дэд сайд С.Зулпхар, ХХҮЕГ, болон холбогдох байгууллагуудын төлөөллүүд оролцсон хурал, уулзалтыг зохион байгуулж, 2023 онд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран ажиллах төлөвлөгөөний төсөлд Програм хөгжүүлэлт /хяналт, тайлагналт/-ийн хүрээнд хийх ажлууд, журам, дүрмийн өөрчлөлт, мэдээллийн урсгалыг сайжруулах асуудлыг тусган батлуулахаар шийдвэрлэв.			√	
65.	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, мэргэжилтнүүдтэй 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулж дараах 4 асуудлыг хэлэлцлээ. Үүнд:				

	<p>1.Ахмад настны үндэсний төвд тусгай зөвшөөрөл олгох асуудал удаашралтай байгааг анхаарч шуурхай шийдвэрлэх, цаашид магадлан итгэмжлэлд хамруулах, ЭМД-ын сангаас санхүүжилт олгох</p> <p>2. Ахмад настны үндэсний төвийн эмч, бусад асрамжийн газрын эмч нарт хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх олгох</p> <p>3.Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний дэмжлэг, хөнгөлөлт, тусламж цахимжиж эхэлж байгаатай уялдуулан Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан журмуудыг шинэчлэн боловсруулахад хамтран ажиллах,</p> <p>4.Нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн салбар хооронд цахим мэдээлэл солилцох, мэдээллийн агуулгыг шинэчлэх, шинээр солилцох мэдээллийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг хамтран байгуулж ойрын хугацаанд эрүүл мэндийн салбараас гарах эмч, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг цахимаар авах хөгжүүлэлт хийх</p>			√	
66.	Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр судалгаа, үнэлгээний “Когнос Интернэйшнл” ХХК Улаанбаатар хотын гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааг гүйцэтгэж, судалгааны тайлан, зөвлөмжтэй танилцан санал өгч ажилласан.			√	
67.	“Олон нийтийн оролцоог түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөл болор гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлнэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ”-гээр магадлан итгэмжлэл авсан ТББ-уудтай хамтран ХХҮЕГ-аас гэр оронгүй, тэнэмэл амьдралтай, архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлох, цаашдын хамтын ажилллагааг идэвхжүүлэх зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулав.			√	
68.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1,2,3 дугаар улирал, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар гаргаж, www.mlsr.mn сайтад байршуулсан.			√	
69.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн дэмжлэгтэйгээр Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх зорилт бүхий төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг танилцуулгын хамт боловсруулан газруудаас санал авахаар хүргүүлээд байна.			√	
70.	Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/2751 дугаар албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ажлын хэсэгт ажиллах гишүүдийн нэрсийг авсан бөгөөд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулахаар тушаалын төслийг 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/3232 тоот албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн.			√	
71.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2022 оны 12 дугаар сард нийт 70 тусгай зөвшөөрөл хүссэн байгууллагууд хүсэлт ирүүлснийг хуульд заасны дагуу нягтлан шалгаж, тусгай зөвшөөрөл олгох эсэхэд дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 3 удаа (2022.11.18, 2022.12.09, 2022.12.27) хуралдаж, дүгнэлт гаргаад байна.			√	
72.	Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож, амжилт гаргасан 35 хүүхдийг урамшуулах нэг удаагийн мөнгөн шагналд 69.000.000 /жаран есөн сая/ төгрөгийг Хүүхдийн төлөө сангаас зарцуулах эрх олгох тухай ХНХ-ын сайдын 2022 оны А/207 дүгээр тушаалыг батлуулж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.			√	
73.	“Хүүхэд харах үйлчилгээнд санхүүжилт олгох тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалыг батлууллаа.			√	
74.	Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хамтран Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын компакт гэрээ”-нд 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр талууд гарын үзэг зурсан. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг		√		

	танилцуулах, хэлэлцэх хоёр улсын Засгийн газрын хамтарсан уулзалтад тус газрын дарга болон холбогдох мэргэжилтнүүд оролцож, илтгэл тавьж санал хэлэлцүүлээ. Уг хамтарсан уулзалт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан.				
75.	Дэлхийн зөн ОУБ, ГББХЗГ-ын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэж, 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.			√	
76.	“Эрэгтэйчүүдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” арга зүйн гарын авлагын төслийг ТББ-ын төлөөлөлд танилцуулж, санал авч, төрийн байгууллагын төлөөлөлд танилцуулж, арга зүйн гарын авлагыг эцэслэлээ.			√	
77.	“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн 2022 оны тайлангийн хуралд тус яамнаас хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хэлэлцүүлж дүгнэв. Мөн түүнчлэн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, НҮБ-ын ХАС-д хүргүүлсэн.			√	
78.	“Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах, чадавхижуулах чиглэлээр гаргасан ололт амжилт, тулгарсан бэрхшээл” сэдэвт НҮБ-ын UNW/2022/007 тоот тогтоолын хэрэгжилтийн талаарх тайланг бэлтгэж, орчуулж байна.				√
79.	ХНХ-ын дэд сайд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Монголын эмэгтэйчүүдийн холбоотой уулзан, “Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн-өдөрлөг” -ийг 2023.02.03-ны өдөр зохион байгуулах болов.				√
80.	“Хүн ам, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт баримтлах жендэрийн бодлого” 2018-2024 онд хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын эхний үе шатны хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайлан мэдээллийг жендэрийн салбар зөвлөлд, Жендэрийн үндэсний хороонд, салбарын нийт ажилтан албан хаагчдад тус тус танилцуулсан.			√	
81.	Халамж, асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдийн зардлын нормативыг шинэчлэх асуудлаар халамж асрамжийн төвүүдийн удирдлагуудтай уулзалт, хэлэлцүүлэг хийж санал солилцов. Үйлчилгээнд шаардагдах бодит зарцуулалт болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын зардлын харьцуулсан судалгаа хийсэн. Мөн нормативыг шинэчлэхээр судалгаа хийж байна.			√	
82.	Уан скай ОУБ-ын удирдлагуудтай цахим хурал хийж хамтран ажиллах төлөвлөлтөө хэлэлцэв. Цаашид хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн ажлын хэсэгт хамтран ажиллаж, бага насны хүүхдүүдтэй ажиллах арга зүйн чиглэлээр хамтарсан сургалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.	√			
83.	Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан мэргэжлийн ангийн хурлыг шуурхай зарлан хуралдуулж, жагсаал, цуглаан, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.	√			
84.	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ТББ-ыг магадлан итгэмжлэх зөвлөл хуралдаж, 14 ТББ-ын материал хүлээн авч судлан, 13 байгууллагад итгэмжлэл олгох шийдвэр гарсан.			√	
85.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн хуралдааныг 12 дугаар сарын 01-ны өдөр Төрийн ордонд өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Тус хуралдаанаар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.		√		
86.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын сургалтыг үйлчилгээний байгууллагын 40 гаруй хүнд зохион байгууллаа. Олон нийтэд түшиглэсэн ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоо, үйлчилгээг хөгжүүлэх нь АХБ-ны бүсийн техникийн туслалцааны ТА 9928 төслийн хүрээнд “Кейс менежмент” -ийн 5 хоногийн сургалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж судалгааг газрын мэргэжилтнүүд болон холбогдох байгууллага, салбар комисст танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. 			√	
87.	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 2019-2022 оны байдлаар эргэн төлөлтийн хувь, хэмжээг тооцон гаргасан.			√	
88.	Бүх яам, аймаг, дүүргүүдийн Засаг дарга нарт Засгийн газрын хуралдааны 34, 33 тэмдэглэлийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлэв.			√	

----- oOo -----